

УДК 24

МОНГОЛЫН БУДДЫН ШАШИН, УТГА СОЁЛ ДАХЬ 108 ТООНЫ БЭЛГЭДЭЛТ УТГА

Өрнөхдэлгэр Д.

Ховд их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Хэл
зохиолын тэнхим. Хэл бичгийн ухааны доктор, профессор
Хаяг: urnukhdelger.d@gmail.com

Хураангуй

Энэхүү өгүүлэл нь Монголын соёл, шашин дахь тоон билэгдэлд (108-ын жишээн дээр) зориулагдсан. Тоонууд нь янз бүрийн соёл, шашны уламжлалд ид шидийн ач холбогдолтой гэж эрт дээр үеэс үздэг. Зуун найм бол дэлхийн тоон зүйд гайхалтай тоо юм. Мөн Буддын шашин ч үл хамаарах зүйл биш юм. Буддын шашин бол дэлхийн хамгийн эртний шашин юм. Зохиогч монголчуудын бэлгэдэх сэтгэлгээнд уламжлагдан ирсэн тооллын код дахь 108 тооны бэлгэдлийн утгыг тайлбарлах логикийг судалж, монгол ардын утга зохиол, соёлын эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан түшиглэн авч үзэхдээ орчин үеийн монголчуудын өвөг дээдэс энэхүү ариун тоонд ямар ач холбогдол өгч байсныг тогтоохыг оролдсон. Буддын шашны сургаалын зарим заалтыг кодчилдог 108 тоо шүтлэг бишрэл, сэтгэлээ ариусгах сүсэг итгэлдээ ямар утга агуулга шингээж ирснийг лавшруулан тодруулсан. Монголчуудын хэрэглэж байсан эрх нь 54, 27, 21, 8 ширхэгтэй байж болно. Уншсан тарнины тоог бөмбөлгүүдийг тоолж тогтоодог. Тойрог бүр 108 удаа давтагдана. Аливаа үйлдлийг 108 удаа давтаж хийсний дараа хүн төгс төгөлдөрт хүрдэг гэж үздэг. Монголчууд тарни уншсан хүн сарнайн дээр тоологдох тарнины тоо дүүрсэн цагт тагнайд нь “Дун шуд” гардаг гэсэн аман домог бий.

Түлхүүр үг

Буддын шашин соёл, 108 тооны бэлгэдэл.

UDC 24

SYMBOLIC MEANING OF THE NUMBER 108 IN CULTURE AND BUDDHISM OF MONGOLIA

Urnokhdelger D.

Department of Linguistics, School of Social Sciences and Humanities, Hovd University

Doctor of Linguistics, Professor

E-mail: urnukhdelger.d@gmail.com

Annotation

This article is devoted to the numerical symbols in Mongolian culture and religion (on the example of 108). Numbers have long been believed to have mystical significance in various cultures and religious traditions. One hundred and eight is an amazing number in world numerology. And Buddhism is no exception. Buddhism is the oldest religion in the world. The author studied the logic of explaining the symbolic meaning of the number 108 in the numerical code inherited from the symbolic thinking of the Mongols, and based on the literary and cultural sources of the Mongolian people, he tried to determine the importance that the ancestors of the modern Mongolians attached to this sacred number. The 108 numbers, which codify some of the teachings of the Buddhist religion, have been clarified by referring to the meanings that have been absorbed into the faith of worshiping and purifying the soul. The rights used by the Mongols could have 54, 27, 21, or 8 pieces. The number of mantras recited is determined by counting the beads. Each round is repeated 108 times. It is believed that after repeating any action 108 times, a person attains perfection. There is an oral legend in Mongolia that the person who recited mantras has “seashell teething” (“Dun shud”) on his palate, when the number of mantras counted by beads on the rosary is fully complete.

Key words

Buddhist religion and culture, 108 number symbolism.

О Р Ш И Л

Хүн төрөлхтөн аливаа зүйлийг цаанаа ямар нэгэн учир зүйтэй байдаг хэмээн сэтгэж, түүндээ бэлгэ ерөөлийн утга агуулга шингээж үздэг сэтгэлгээний өвөрмөц аргатай. Монголчууд “амны бэлгээс ашдын бэлэг” хэмээх хэлцээр ярилцаж, аливаа бэлгэдлийг ихэд эрхэмлэн үзсээр ирсэн ард түмэн юм. Тиймээс, “Энэтхэг хүн билгээр, төвөд хүн сүсгээр, хятад хүн бэлээр, монгол хүн бэлгээр” асуудалд ханддаг гэх үгс гарсан нь мэдээж. Монголчуудын бэлгэдэх сэтгэлгээний ай савыг нэрт бэлгэдэл зүйч, профессор С.Дулам багш тооны, өнгөний, зүг чигийн, зүүд, зөн совингийн, цагийн, дохио зангааны, дүрсийн гэж ангилан үзэж, нарийвчлан судлахдаа монгол аман зохиол утга зохиолын их ай савыг эх сурвалжаа болгоод зогссонгүй, аман түүх соёлын мэдээг чухалчлан үзсэн билээ.

Бэлгэдлийн айн нэгэн зүйл нь тооны бэлгэдэл юм. Эрт цагаас тоог зөвхөн тооллын учир зорилгоор бус бэлгэдлийн утга аясаар боловсруулан хөгжүүлсээр иржээ. Тоо нь гагцхүү хэмжээг бус бас утга санаа, хүчин чадлыг илэрхийлдэг. “Уламжлалт соёл сэтгэлгээнд тоо бол юм, үзэгдэл, үйл явдлын үнэн мөнийг хүрэлцэн ойлгох ер бишийн гайхалтай учир холбогдолтой зүйл байдаг” (Дулам, 2007: 23).

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Уламжлалт мэдлэг ухаан болон бурхны шашны зан үйлд 108-ийн тоо нь үлэмж олны, цааш өсөн дэлгэрэхийн бэлгэдэлт шинжийг илэрхийлэх нь түгээмэл аж. Үүнд:

- Шашин сүм хийд, хот суурингийн бүтээн байгуулалт (*эрт цагийн Эрдэнэзуу хийдийн 108 суварга, эдүгээ үеийн Завхан, Ховд аймагт байгуулсан 108 суварга*);
- Шүтлэг мөргөлийн зан үйл (*108 зул өргөж буян үйлдэх ёс, 108 удаа сунаж мөргөх*);

• Ном, эд өлгийн зүйлс (108 тоотой маанийн эрих, Ганжуур буюу Зарлигийн орчуулгын 108 боть /Лигдэн хааны зарлигаар 1629 онд 50 гаруй хэлмэрч орчуулсан “Ганжуур” хэмээх хөлгөн их судар 100 шахам жил гар бичмэлээр дэлгэрч байгаад 1717-1720 оны хооронд модон бараар хэвлэгдсэн байна (Цэрэнсодном, 2007: 65) / гэх зэрэг жишээг дурдаж болно).

Дэлхий нийтэд 108 тоо нь ямар учиртай болохыг дараах гурван янзын үзлээр тайлбарлажээ. Үүнд:

1. Энэтхэгийн шашны уламжлалд шидэт гурвалжин гэх ойлголт байдаг бөгөөд үүнийг бие биеэр нь үржүүлэхэд 108 гэсэн хариу гардаг.

2. 108 гэдэг нь 12 сар, 24 хувирган сар, 72 таван өдрийн нийлбэрийг бэлгэдсэн Одон орон судлалын учир холбогдолтой.

3. 108 тоог нэгж болгон 1, 100, 7 гэж задлаад, 1 нь нарны бэлгэдэл, 100 нь нарны туяа, 7 нь нарыг эргэж байдаг гараг эрхэсийн тоо юм гэж үздэг.

Эдгээрээс маани уншин буян хураах эрих яагаад 108 тоотой байдаг тухай, монголчуудын түгээмэл хэрэглэдэг эрихний эд материалын бэлгэдлийн утга, маани тоолох ёс зэргийг тодруулан авч үзье. Юуны өмнө, “Эрих” хэмээх үгийн утгыг Я. Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д, “Тоог тэмдэглэх хэрэгсэл, юмны тоог авах ба зүүлт чимэгт хэрэглэнэ” (Цэвэл, 1966) гэж тайлбарласан бол “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д, “1: Зандан, хас, шүр, сувд зэргийг тодорхой

тоогоор хэлхэн маани мэгзэм уншсан тоогоо тэмдэглэх хэрэглэл, 2. Сувд, шүр зэрэг үнэт эдлэлээр хэлхсэн хүзүү бугуйн чимэг 3. Сампингийн мөхлөг” (Монгол хэлний..., 2008) гэж тайлбарласнаас үзэхэд эрих гэдэг нь тодорхой тооны мөхлөг эдийг утас зэрэгт хэлхсэн зүйлийн ерөнхий нэр болох нь харагдаж байна.

Мөн Энэтхэг, Төвд, Монгол зэрэг эртний номт гурван улсын эрдэмтэн мэргэдийн зохиол бичих нэгэн зүйл арга, маягийг “эрих” гэж нэрлэдэг ажээ. Энэ тухай доктор, профессор Д.Галбаатар, “Эрих гэдэг нэр томьёо нь зохиолын хэрэг явдлын дэс дарааллыг алдагдуулаагүй тус тус бие даасан хэсэг болгож зохиомжлох уран дүрслэл болон түүхэн баримтыг солбицуулан хослуулж, эрих маягаар зохиомжилсон зохиолыг заана. Эрихний мөхлөг мэт хоорондоо холбоо бүхий олон янзын баримт, түүх, дуулал, шүлэг, домог мэтийг нэгэн гол зүйл явдалд нэгтгэн зангидаж бичих ёс нь эртнээс монголчуудын угийн бичиг, домог үлгэр, түүх, түүхт явдал, уран сэтгэмж, баримтын уран сайхны зорилгоор зориудаар эрихчлэн нэгэн гол утга санаанд хэлхэн өгүүлэх өвөрмөц арга, зохиомжийн нэг хэлбэр. Ийм зохиомжтой бүтээл буюу эрих хэмээх нэр томьёо “Монголын нууц товчооноос XVII-XVIII зууны үеийн түүхэн сурвалж бичиг, түүхэн уран зохиолд өргөн хэрэглэгдэх болжээ. Жишээ нь: Рашидунцагийн “Дай Юан улсын болор эрих”, Галдан туслагчийн “Эрдэнийн эрих” гэх мэт” (Галбаатар, 2012) хэмээжээ.

Буддын шашны Махаяна Хинаяна буюу их хөлгөн, бага хөлгөний ёсонд бясалгал хийж, өөрийн сэтгэлийг нэгэн үзүүрт чиглүүлэхэд эрихийг хэрэглэдэг байна (Чулуунбаатар, 2005). Зөвхөн буддын шашин төдийгүй Европчууд “Библи” судрын хамт эрихийг Бурхан тэнгэрт хандахад тусалдаг зэмсэг гэж үзээд эрихийг хэрэглэдэг бол Оросын үнэн алдартны шашинд залбирал үйлдэхдээ эрихээ 7 удаа эргүүлдэг аж. Орос Европ эрих 1 толгой, 7 мөхлөгтэй, буддын шашинтан 108 мөхлөгтэй эрих хэрэглэдэг. Ерөөс буддын шашинтны эрих 108 мөхлөгтэй байдаг нь тооны бэлгэдэлтэй нягт холбоотой юм. 108 тооны бэлгэдлийн утга учрыг тодруулан үзэхэд хоёр янзын тайлбар гарч ирнэ. Тухайлбал:

Бага хөлгөний ёс буюу доод авидармын тогтсон таалалд дараах 2 янзын тайлбар бий. Үүнд:

- Нүд, чих, хамар, бие, хэл, сэтгэл /ухаан/ тэргүүтэн мэдрэхүйн 6 эрхтэн, тэдгээрийн баригдахуун болох дүрс, дуу, үнэр, амт, хүлэлцэхүй, ном тэргүүтэн 6 зүйл вишай /юм/-г цаг ямагт шүтэлцэн байх төрөн түгэхүйн бэлгэдэл нь 12 буюу $6+6=12$ болно. Нөгөөтэйгүүр бие, хэл, сэтгэлээс үүдэх 3 их хүслэн нь энэ хийгээд өнгөрсөн улмаар ирээдүйн 3 цагт тасралтгүй үргэлжлэн мөнхөд оршиж, нэгэн төрлөөс нөгөөд төрөл юүлсээр байхын бэлгэдэл нь 9 буюу $3 \times 3=9$ юм. Дээрх 12 төрөн түгэхүй нь үйлийн үрийн үргэлжлэл болсон 9 ахуй учралтай шүтэлцэхийг 108 буюу $12 \times 9=108$ тоогоор бэлгэдсэн хэмээх үзэл.

- Мэдрэхүйн 6 эрхтэн, 6 баригдахуун /вишай/-ны үр дагаврын шалтгааныг тооцон 36 тоогоор бэлгэдсэн нь $6 \times 6=36$ болно. Энэхүү шалтгаан үрийн боловсрол өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт ямагт тасрахгүй илтгэн $36 \times 3=108$ хэмээх үржвэр гарган 108 тооны бэлгэдэлд үйлийн үрийн шүтэлцээг хадаж өгчээ.

Тэгвэл их хөлгөний /махаяна их хөлгөний/ ёс буюу дээд авидармын тогтсон тааллыг баримталдаг дорнын номт гурван улсын нэг хэмээгдэх монгол орны буддистуудын 108 тоотой эрих хэрэглэдэг нь буддын дундад үзлийн ёсны философи сэтгэлгээтэй холбоотой хэмээн гүн ухаантан академич, доктор Ч.Жүгдэр үзэж байжээ.

Дундад үзэлтэн нь аливаа юмс үзэгдлийг түрдэхгүй, төрөхгүй, мөнхгүй, тасархайгүй, нэгэн чанартай бус, өөр чанартай бус, ирэхгүй, одохгүй хэмээх эсрэг, тэсрэг 4 зүйлийн шүтэн барилдлагын ёсоор аливаа зүйлсийг танин барих арга ухаанаар инагуух бодгалийн “би-үгүй” хийгээд чинагуух номын “би-үгүй”-г онон барьж, мөнхүү чанар буюу “хоосон чанар”-ыг нээж чадсан бэлгэ билгүүнийг номлогчдыг нэрлэж буй юм. Өөрөөр хэлбэл, аливаа юм үзэгдэл нь бүтэхийн хамт эвдэрч, эвдрэхийн хамт бүтэж, үргэлжлэхийн хамт тасарч, тасрахын хамт үргэлжилж, салахын хамт нийлж, нийлэхийн хамт салж, үгүй болохын хамт буй болж, буй болохын хамт үгүй болж байдаг шүтэн барилдлагыг танин мэднэ гэсэн үг ажээ.

Дундад үзлийн ёсыг баримтлагчид сэрэхүйн эрхтнүүдэд мэдрэгдэж, сэрлээр дамжин сэтгэхүйд танигдах орчлонг буй болгож байгаа бодис 108 юм гэжээ. Тэд хэдийгээр юм нэг байдлаас нөгөө байдалд шилжих боловч махбодын тоо эвдрэхгүй. Хэрэв аль нэг нь эвдрэх аваас орчлон сөнөнө гэж үзжээ. Эдгээр махбод эвдрэхгүй эвдрэх хоёрын дундаж “хоосон чанар”-т байх аваас орчлон бат байна гэжээ. Үүний учир эрихийг 108 мөхлөгтэй хийдэг ажээ. Үүнээс үзэхэд 108 хэмээгч тоо орчлонг буй болгогч махбодын тоо ажээ.

Монголчуудын хэрэглэдэг эрих 108, 54, 27, 21, 18 мөхлөгтэй байдаг. Монголчууд эрих барьж маани эргүүлэн уншдаг. Тэгэхдээ 108 мөхлөгтэй том эрихнээс гадна 21 юмуу эсвэл 108 мөхлөгтэй хоёр янзын эрих барьж тоолдог. Тэр хоёр эрихэндээ өөр өөр өнгийн утсаар уншсан маанийхаа тоог тэмдэглэх гогцоо хийдэг. 108 тоотой эрихийг нэг бүтэн эргүүлэн жижиг эрихний гогцоог нэг мөхлөг хоошлуулан ухраах зэргээр уншсан маанийхаа тоог тэмдэглэнэ. Ингэж тоолсоор жижиг эрих нэг бүтэн тойроход 108 тоотой эрихний гогцоог ухраан 1 тоо хийнэ. Маанийг төд хүртэл уншихад тоо нь гүйцнэ гэсэн тодорхой заасан тоо байдаггүй ч эрихэндээ уншсан мааниа тоолон уншсаар тоо нь гүйцэхээрээ маань баяжуулсан хүний тагнайд нь “Дун шүд”¹ ургадаг хэмээх аман домог монгол нутагт яригдсаар байна.

Ийнхүү Монголчууд 108 тоотой эрихийг буян хураахад хэрэглэхээс гадна ахуйн хэрэглээнд 108 тоогоор гүйцэтгэх ажилбарыг эрихээ эргүүлэн мэддэг. Үүний нэг жишээ нь Төв халхчууд чанаж буй цайгаа эрих тоолон 108 удаа самардаг байна.

Монголын буддистууд эрихийг ариун эд хэмээн үздэг учир зориулалт хийгээд лам нар зэрэг дэвээсээ шалтгаалан янз бүрийн үнэт материалаар хийнэ. Үүнд алтан мөхлөгтэй (мөхлөг гэж 108-ын 1/4 буюу 27-гийн дэргэд хийсэн 28 дахь нь) сувдан эрих, алт, сувдан мөхлөгтэй шүрэн эрих гэх мэт үнэт эрихнүүдээс гадна төрөл бүрийн мод, жимсний үрээр хийсэн эрихийг ихэд дээдлэн үздэг байна. Эдгээрээс дурдвал,

1. *Гүррагчаа эрих*: Хятад, Энэтхэг, Балба, Кашмирт ургадаг модны жимсний үр

2. *Мэг Бодь эрих*: Хутагт мэлмий гэсэн утгатай төвд үг. Балба, Энэтхэг, Хятдын өмнөд мужуудад ургадаг модны жимсний үрээр хийдэг. Үүний онцлог нь энэ жимсний үр нь хоёр талдаа мэлмийн дүрстэй байдаг учир “билгүүний нүдэн” нээгдэхэд тустай хэмээн Төвд, Монголчууд ихэд бэлгэшээдэг.

¹Дун шүд — Маани уншсаар байгаад дээд тагнайд гарах шүд. Тийм шүд ургатал маани уншсан хүнийг их буян хураасан гэх бөгөөд үр хойч нь хэдэн үедээ сайн явдаг гэж ярьдаг. Дун шүдийг нь унахаар авч хадганд боогоод бурхан шүтээндээ залж шүтдэг аж (Аман мэдээ өгсөн: Завхан аймгийн Отгон сумын Бадрал багийн иргэн 75 настай Шугархүү, эр. Өгүүллийг бичигч 2016 оны 8 сарын 21-ний өдөр тэмдэглэв авав).

3. *Бадма нямбу эрих*: Лянхуан зүрхэн буюу цэцгийн шим гэсэн утгатай. Энэ жимс нь Хятдын өмнөд, зүүн өмнөд нутаг, Индонези, Балбын өмнөд хэсэг, Бутан мөн Орос болон Европын бусад нутгуудад ургадаг анар жимсний нэг төрөл. Хунхарцаг дотроо 108 ширхэг мөхлөгтэй, мөхлөг тус бүр өөртөө үртэй. Энэ нь Буддын шашны 108-ын бэлгэдэлт утгатай ижил тоотой учир буян хураахад бүтээл ихтэй гэж бэлгэшээдэг.

4. *Зургаадай эрих*: Ховор модон эрих. Энэ мод нь цагаан бургасны нэг төрөл бөгөөд Богд Зонховын үеэс төвдийн өндөр ууланд ургадаг болсон домогтой. Голоосоо гадагшаа зургаан цагаан зураасан ширхэгтэй модоор хийсэн эрих. Маанийн зургаан үсэгт зориулагдсан бурханаас заяасан мод гэж үздэг. Ийм учир барьсан эзэндээ урт нас, буян их хайрладаг, хураалгадаг гэдэг. Монгол ардын аман зохиолд байдаг “Зуу насалж Зургаадай таяг тулаарай” гэсэн ерөөл бэлгийн үг нь үүнтэй холбоотой ажээ. Түүнчлэн, монгол нутагт ургасан мод бут, чулуугаар хийсэн эрих ард түмний дунд одоо хүртэл өвлөгдөн үлдсэн нь биднийг хээрийн судалгаа хийх үед нэлээд таарч байсны нэг нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумынхан барьдаг эрих байлаа.

Сүүлийн үед, эрдэмэд эрихийг анагаах удистай хэмээн үзсэн байна. Хүний хуруу, гарын алга зэрэгт уураг тархийг бусад эрхтэнтэй холбосон мэдрэлийн олон мянган нарийн судал байх ба эдгээрийг үрэх зэргээр хөдөлгөөнтэй байлгавал эд эсүүд сэргэдэг ажээ. Эрих имрэн олон юм бодохгүй анхаарлаа төвлөрүүлнэ гэдэг бол хурууны үзүүрийн мэдрэлд зүү тавихтай адил нөлөөлнө гэж үздэг.

Мөн балчир хүүхдийн сэтгэхүйг судалдаг судлаачид хурууны үзүүрийг хөдөлгөхөд тархины үг хэлэх чадварт нөлөөлж, хүүхдийн хэл ярианы хөгжилд зохих үр дүнгээ өгдөг гэж үзсэн байна. Хүүхдийг 6-7 сартайгаас эхлэн хурууны үзүүрийг илж имрэх, эрихээр тоглуулах, товчоор оролдуулахад сайн үр нөлөөтэй. Ойндoo хүрсэн хүүхэд товчоо товчлох, тайлах, уяа зангилаа уях, гутлынхаа үдээсийг үдэх тайлах, эрих имрэх зэрэг дасгал сургууль хийлгэвэл хэл ярианы хөгжил сайжирдаг байна.

Монгол оронд шашин дэлгэрэхтэй зэрэгцэн орж ирсэн шашны утга агуулга, бэлгэдэлт 108 тоо нь өдгөө манай ард түмний сайн сайхны бэлгэдэлт тоо болон утга агуулга нь улам баяжиж байна. “Монголын уран зохиолын дээж” 108 боть, зарим нэгэн зохиолч яруу найрагчид зохиол бүтээлээ 108 тоогоор эсвэл 108-аар ботилж хэвлүүлэх, ахуй соёлд ядаргаа тайлах цайгаа 108 удаа самрах зэргийг энэ тооны бэлгэдлийн утгад хамааруулан үзэж болох юм.

ДҮГНЭЛТ

- Маанийн зургаан үсгийг уншихдаа үйл үрийн шалтгаант сансар нисваанисын хүрднээс гэтлэхийн тухайд эх болсон зургаан зүйл амьтны зовлонг амирлуулах чанадын зорилгыг үргэлж агуулж, сүсэг итгэлийн орон болгон, бэлгэдэл шингэсэн 108 тоот эрих эргүүлдэг учир нь тэр ажгуу.

- 108-ын тооны бэлгэдлийн утгыг агуулсан эрих нь монголчуудын ахуй амьдрал, шашны зан үйл, мэргэ төлгө зэрэгт өргөн хэрэглэгддэг бөгөөд хэрэглээний хүрээ хязгаар, эрихийг хийж бүтээх явц, орц зэрэг нь монгол утга соёлын салшгүй нэгэн судлагдахуун мөн.

Ном зүй

- Галбаатар, Д. (2012). *Уран зохиолын нэвтэрхий толь*. Улаанбаатар.
Дулам С. (2007). *Монгол бэлгэдэл зүй I. Тооны бэлгэдэл зүй*. Улаанбаатар.
Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь (2008). Ерөнхий ред. Л. Болд. Улаанбаатар.
Омакаева, Э.У. (2001). Число и цвет в текстах калмыцкой мифоритуальной традиции. *Смыслы мифа: мифология в истории и культуре*. 8. Сборник в честь 90-летия профессора М.И. Шахновича. Санкт-Петербург: Санкт-Петербургское философское общество. 65-67 (in Russian).
Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар.
Цэрэнсодном, Д. (2007). *Монголын бурханы шашны уран зохиол*. Улаанбаатар.
Чулуунбаатар, Ш. (2005). Хүн гэдэг амьтан чинь... Улаанбаатар: Согоо нуур.

References

- Galbaatar, D. (2012). *Uran zokhiolyn nehvtehrkhij tol'*. Ulaanbaatar.
Dulam, S. (2007). *Mongol behlgehdehl zyj I. Toony behlgehdehl zyj*. Ulaanbaatar.
Mongol khehlnij dehlgehrengyj tajlbar tol' (2008). Erönkhij red. L. Bold. Ulaanbaatar.
Omakayeva, E.U. (2001). Chislo i tsvet v tekstakh kalmytskoj miforitual'noj traditsii. *Smysly mifa: mifologiya v istorii i kul'ture*. 8. Sbornik v chest' 90-letiya professora M.I. Shakhnovicha. Sankt-Peterburg: Sankt-Peterburgskoe filosofskoe obshhestvo. 65-67 (in Russian).
Tsevel, Ya. (1966). *Mongol khehlnij tovch tajlbar tol'*. Ulaanbaatar.
TSehrehnsodnom, D. (2007). *Mongolyn burkhany shashny uran zokhiol*. Ulaanbaatar.
CHuluunbaatar, SH. (2005). *KHyn gehdehg am'tan chin'...* Ulaanbaatar: Sogoo nuur.